



IAF Mandatory Document

ОУИФ Заавал мөрдөх баримт бичиг

**ISO/IEC 17021-1 СТАНДАРТЫГ ХЭРЭГЛЭЭ:
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ
АХУЙН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО
(ХАБЭАМТ)-НЫ БАТАЛГААЖУУЛАЛТ**

**APPLICATION OF ISO/IEC 17021-1 FOR THE
CERTIFICATION OF OCCUPATIONAL HEALTH
AND SAFETY MANAGEMENT SYSTEMS
(OH&SMS)**

Хэвлэл 2, Хувилбар 2

(IAF MD 22:2023)

Хэвлэсэн огноо: 14.06.2023

Хэрэгжиж эхлэх огноо: 07.05.2020

Олон Улсын Итгэмжлэлийн Форум (ОУИФ) нь ОУИФ-ын гишүүнээр итгэмжлэгдсэн Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-ын гаргасан үр дүнг дэлхий даяар хүлээн зөвшөөрч, Итгэмжлэлийн байгууллага (ИБ)-уудын дунд дэлхий хэмжээний харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийг хэрэгжүүлэх замаар үйлдвэрлэгч болон зохицуулагч байгууллагуудад дэмжлэг үзүүлэн худалдааг хөнгөвчилдөг.

Итгэмжлэл нь итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-ууд итгэмжлэлийн хамрах хүрээнд багтсан ажлаа гүйцэтгэх чадамжтайг батлах замаар бизнес болон тэдгээрийн хэрэглэгчдэд учрах эрсдэлийг бууруулдаг. ОУИФ-ын гишүүн ИБ болон тэдгээрийн итгэмжлэгдсэн ТҮБ-ууд нь олон улсын стандарт, тэдгээр стандартын хэрэглээний нийцтэй байдалд зориулсан ОУИФ-ын заавал дагаж мөрдөх баримт бичгийг мөрдөх шаардлагатай.

ОУИФ-ын Олон талт харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр (ХХЗХ)-т нэгдсэн ИБ-уудын итгэмжлэлийн хөтөлбөрийн үйл ажиллагаанд итгэлийг бий болгохын тулд ижил түвшний багаас бүрдсэн үнэлгээг тогтмол явуулдаг. ОУИФ-ын ХХЗХ-ийн бүтцийн талаар ОУИФ-ын бодлогын баримт бичиг 3 (IAF PL 3) “ОУИФ-ын ХХЗХ-ийн хамрах хүрээний бүтэц ба ОУИФ-ын ХХЗХ-ийн хамрах хүрээний өргөтгөлийн бодлого, журам”-д дэлгэрэнгүй тусгасан. Мөн ОУИФ-ын ХХЗХ-ийн хамрах хүрээний талаар ОУИФ-ын ХХЗХ-ийн статус баримт бичигт тусгасан.

ОУИФ-ын ХХЗХ-ийн нь дараах таван түвшний бүтэцтэй. Үүнд:
1-р түвшин нь ISO/IEC 17011 стандартыг хэрэгжүүлэгч бүх ИБ-уудад хамаарах заавал мөрдөх шалгуурыг тодорхойлно. 2-р түвшний үйл ажиллагаа болон холбогдох 3-р түвшний норматив баримт бичиг(үүд)-ийн нэгдлийг ХХЗХ-ийн үндсэн хамрах хүрээ гэж нэрлэдэг.

The International Accreditation Forum, Inc. (IAF) facilitates trade and supports industry and regulators by operating a worldwide mutual recognition arrangement among Accreditation Bodies (ABs) in order that the results issued by Conformity Assessment Bodies (CABs) accredited by IAF members can be accepted globally.

Accreditation reduces risk for business and its customers by assuring them that accredited CABs are competent to carry out the work they undertake within their scope of accreditation. ABs that are members of IAF and their accredited CABs are required to comply with appropriate international standards and IAF mandatory documents for the consistent application of those standards.

ABs that are signatories to the IAF Multilateral Recognition Arrangement (MLA) are evaluated regularly by an appointed team of peers to provide confidence in the operation of their accreditation programs. The structure of the IAF MLA is detailed in IAF PL 3 - Policies and Procedures on the IAF MLA Structure and for Expansion of the Scope of the IAF MLA. The scope of the IAF MLA is detailed in the IAF MLA Status document.

The IAF MLA is structured in five levels: Level 1 specifies mandatory criteria that apply to all ABs, ISO/IEC 17011. The combination of a Level 2 activity(ies) and the corresponding Level 3 normative document(s) is called the main scope of the MLA, and the combination of Level 4 (if applicable) and Level 5 relevant normative documents is called a sub-scope of the MLA.

4-р түвшин (хэрэв байгаа бол) болон 5-р түвшний холбогдох норматив баримт бичгийн нэгдлийг ХХЗХ-ийн дэд хамрах хүрээ гэж нэрлэдэг.

- ХХЗХ-ийн үндсэн хамрах хүрээнд бүтээгдэхүүний баталгаажуулалт гэх мэт үйл ажиллагаа болон ISO/IEC 17065 зэрэг холбогдох заавал мөрдөх стандарт багтана. Үндсэн хамрах хүрээний түвшинд ТҮБ-ын хийсэн баталгааг ижил найдвартай гэж үзнэ.
- ХХЗХ-ийн дэд хүрээнд тохирлын үнэлгээний шаардлагууд буюу ISO 9001 болон схемийн тусгай шаардлага, тухайлбал ISO 22003-1 стандартууд багтана. Дэд хамрах хүрээний түвшинд ТҮБ-ын хийсэн баталгааг ижил тэнцүү гэж үзнэ.

ОУИФ-ын ХХЗХ нь тохирлын үнэлгээний үр дүнг зах зээл хүлээн зөвшөөрөхөд шаардлагатай итгэлийг төрүүлдэг. ОУИФ-ын ХХЗХ-т гарын үсэг зурсан ИБ-аар итгэмжлэгдсэн байгууллагын ОУИФ-ын ХХЗХ-ийн хүрээнд гаргасан баталгааг дэлхий дахинд хүлээн зөвшөөрч, улмаар олон улсын худалдааг хөнгөвчилнө.

Хэвлэл 2, Хувилбар 2
Боловсруулсан: ОУИФ-ын Техникийн хороо
Баталсан: ОУИФ-ын гишүүд
Огноо: 18.03.2019
Хэвлэсэн огноо: 14.06.2023
Хэрэгжиж эхлэх огноо: 07.05.2020
Холбоо барих: Элва Нилсен
ОУИФ Нарийн бичгийн дарга
Утас: +1 613 454-8159
И-мейл: secretary@iaf.nu

- The main scope of the MLA includes activities e.g. product certification and associated mandated standards e.g. ISO/IEC 17065. The attestations made by CABs at the main scope level are considered to be equally reliable.
- The sub scope of the MLA includes conformity assessment requirements e.g. ISO 9001 and scheme specific requirements, where applicable, e.g. ISO 22003-1. The attestations made by CABs at the sub scope level are considered to be equivalent.

The IAF MLA delivers the confidence needed for market acceptance of conformity assessment outcomes. An attestation issued, within the scope of the IAF MLA, by a body that is accredited by an IAF MLA signatory AB can be recognized worldwide, thereby facilitating international trade.

Issue 2, Version 2
Prepared by: IAF Technical Committee
Approved by: IAF Members
Date: 18 March 2019
Issue Date: 14 June 2023
Application Date: 07 May 2020
Name for Enquiries: Elva Nilsen
IAF Corporate Secretary
Contact Phone: +1 (613) 454 8159
Email: secretary@iaf.nu

АГУУЛГА

0. ТАНИЛЦУУЛГА
1. ТОДОРХОЙЛОЛТ
2. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ
3. НЭР ТОМЪЁО, ТОДОРХОЙЛОЛТ
4. ЗАРЧИМ
5. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА
6. БҮТЦИЙН ШААРДЛАГА
7. НӨӨЦИЙН ШААРДЛАГА
8. МЭДЭЭЛЛИЙН ШААРДЛАГА
9. ҮЙЛ ЯВЦЫН ШААРДЛАГА
 - 9.1 Баталгаажуулалтын өмнөх үйл ажиллагаа
 - 9.2 Аудитын төлөвлөлт
 - 9.3 Анхдагч баталгаажуулалт
 - 9.4 Аудит явуулах
 - 9.5 Баталгаажуулалтын шийдвэр
 - 9.6 Баталгаажуулалтыг хадгалах
 - 9.7 Давж заалдах
 - 9.8 Гомдол
 - 9.9 Үйлчлүүлэгчийн бүртгэл
10. БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Хавсралт А – Итгэмжлэгдсэн ХАБЭАМТ-ны баталгаажуулалтын хууль, эрх зүйн нийцэл

Хавсралт В – Итгэмжлэлийн хүрээ

TABLE OF CONTENTS

0. INTRODUCTION
1. DEFINITIONS
2. NORMATIVE REFERENCES
3. TERMS AND DEFINITIONS
4. PRINCIPLES
5. GENERAL REQUIREMENTS
6. STRUCTURAL REQUIREMENTS
7. RESOURCE REQUIREMENTS
8. INFORMATION REQUIREMENTS
9. PROCESS REQUIREMENTS
 - 9.1 Pre-Certification Activities
 - 9.2 Planning Audits
 - 9.3 Initial Certification
 - 9.4 Conducting Audits
 - 9.5 Certification Decision
 - 9.6 Maintaining Certification
 - 9.7 Appeals
 - 9.8 Complaints
 - 9.9 Client Records
10. MANAGEMENT SYSTEM REQUIREMENTS FOR CERTIFICATION BODIES

Annex A (normative) – Legal compliance as a part of accredited OH&SMS certification

Annex B (normative) – Scope of accreditation

ОУИФ-ЫН ЗААВАЛ МӨРДӨХ БАРИМТ БИЧГИЙН ТАНИЛЦУУЛГА

Энэ баримт бичигт хэрэглэгдэх “байвал зохино” нэр томъёо нь шаардлагыг биелүүлнэ гэсэн утгыг илэрхийлнэ. Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ) нь итгэмжлэлийн байгууллагад (ИБ) нотлон харуулсан ижил аргаар эдгээр шаардлагыг биелүүлнэ. Энэ баримт бичигт хэрэглэгдэх “байх ёстой” нэр томъёо нь заавал мөрдөх холбогдох стандартын шаардлагыг заана.

INTRODUCTION TO IAF MANDATORY DOCUMENTS

The term “should” is used in this document to indicate recognised means of meeting the requirements of the standard. A Conformity Assessment Body (CAB) can meet these in an equivalent way provided this can be demonstrated to an Accreditation Body (AB). The term “shall” is used in this document to indicate those provisions which, reflecting the requirements of the relevant standard, are mandatory.

**ISO/IEC 17021-1 стандартыг хэрэглээ:
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн
менежментийн тогтолцоо (ХАБЭАМТ)-ны
баталгаажуулалт**

0 ТАНИЛЦУУЛГА

Баталгаажуулалтын байгууллага нь Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны (ХЭМАБ) гэрчилгээ олгохдоо ISO/IEC 17021-1:2015 стандартыг тууштай хэрэгжүүлэхэд энэхүү баримт бичгийг заавал мөрдлөг болгох шаардлагатай. ISO/IEC 17021-1:2015 стандартын бүх заалт, хавсралтууд хүчин төгөлдөр мөрдөгдөх бөгөөд энэхүү баримт бичиг нь уг стандартын аль нэг шаардлагыг орлохгүй. Энэхүү баримт бичиг нь зөвхөн OHSAS 18001 стандартын гэрчилгээ олгоход хамаарахгүй ба ISO 45001 болон ХЭМАБ бусад стандартын баталгаажуулалтад ашиглагдана. Энэхүү баримт бичигтэй зөрчилдсөн тохиолдолд үндэсний хууль тогтоомжийг баримтална.

Энэхүү баримт бичиг нь 1-дүгээрт ХЭМАБ-н тусгай шаардлагыг танилцуулсан таван заавал мөрдөх баримт бичгийн хавсралтыг багтаасан болно. Тэдгээрийн нэгийг устгаж, ISO/IEC TS 17021-10:2018 стандартаар бүрэн сольсон. Тэдгээрийн хоёрыг хассан бөгөөд IAF MD5:2019 болон IAF MD17:2019 хувилбаруудад бүх шаардлагыг тус тус оруулсан болно.

Энэ 2 дугаарт дараах IAF болон EA баримт бичигт ХЭМАБ тусгай шаардлагуудыг танилцуулсан хоёр заавал мөрдөх хавсралт багтсан болно.

**Application of ISO/IEC 17021-1 for the
certification of Occupational Health and Safety
Management Systems (OH&SMS)**

0 INTRODUCTION

This document is mandatory for the consistent application of ISO/IEC 17021-1:2015 for the accreditation of Certification Bodies providing certification of Occupational Health and Safety Management Systems (OH&SMS). All clauses and Annexes of ISO/IEC 17021-1:2015 continue to apply and this document does not supersede any of the requirements of that standard. This document not only applies for certification to OHSAS 18001 but shall also be used for certification to other OH&SMS such as ISO 45001 and other standards. National legislation will prevail in case of conflict with this document.

This document in its issue 1 included five mandatory appendices which introduced specific OH&SMS requirements. One of them has been removed and totally replaced by ISO/IEC TS 17021-10:2018. Two of them have been removed and all requirements included in the versions of IAF MD5:2019 and IAF MD17:2019 respectively.

This issue 2 includes two mandatory appendices which introduce specific OH&SMS requirements to the following IAF and EA documents:

Хавсралт <i>Appendices</i>	Эх сурвалж / лавлагаа баримт бичиг <i>Source / reference document</i>
Хавсралт А – Итгэмжлэгдсэн ХЭМАБМТ-ны баталгаажуулалтын хууль, эрх зүйн нийцэл <i>Appendix A - Legal Compliance as a Part of Accredited OH&SMS Certification</i>	EA-7/04 M:2017
Хавсралт В – Итгэмжлэлийн хүрээ <i>Appendix B - Scope of Accreditation</i>	IAF-ID1:2014

Энэхүү баримт бичиг нь ISO/IEC 17021-1:2015 стандартын бүтцийг дагаж мөрддөг

Тодорхой шалгууруудыг ISO/IEC 17021-1:2015 стандартын холбогдох шаардлагын заалтыг агуулсан лавлагааны дугаарын хамт "G" үсгээр тодорхойлно.

Бүх тохиолдолд, өөрөөр заагаагүй бол энэхүү баримт бичгийн текст дэх "бүлэг XX"-ийн ишлэл нь ISO/IEC 17021-1:2015 стандартын заалтыг хэлнэ.

Олон салбартай байгууллагуудад IAF MD1:2018 хамаарна. Энэхүү баримт бичиг нь ХЭМАБ-тай холбоотой нэмэлт шаардлагуудыг агуулдаг.

1 ХАМРАХ ХҮРЭЭ

Нэмэлт шаардлага байхгүй.

2 НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

Нэмэлт шаардлага байхгүй.

3 НЭР ТОМЪЁО, ТОДОРХОЙЛОЛТ

G 3.3 ISO/IEC 17021-1 стандартаас гадна хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын чиглэлээр үзүүлж буй нэмэлт үйлчилгээ, зөвлөх үйлчилгээг менежментийн тогтолцоо гэж үзнэ. Үүнд дараахь зүйлс орно, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй:

- i) Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын зохицуулагчийн үүргийг гүйцэтгэх,
- ii) Аюулгүй байдлын тайлан,
- iii) Эрсдэлийн үнэлгээ хийх,
- iv) Үйлчлүүлэгчийн нэрийн өмнөөс зохицуулах байгууллагатай харилцах, мөн
- v) Осол, ослын судалгаа.

4 ЗАРЧИМ

This document follows the structure of ISO/IEC 17021-1:2015.

Specific criteria are identified by the letter "G" followed with a reference number that incorporates the related requirements clause in ISO/IEC 17021-1:2015.

In all cases a reference in the text of this document to "clause XX" refers to a clause in ISO/IEC 17021-1:2015 unless otherwise specified.

For multi-site organisations IAF MD1:2018 applies. This document provides additional requirements in relation to OH&SMS.

1 SCOPE

No additional requirement.

2 NORMATIVE REFERENCES

No additional requirement.

3 TERMS AND DEFINITIONS

G 3.3 In addition to ISO/IEC 17021-1, additional services provided in the field of Occupational Health and Safety are also considered as management systems consultancy. These include, but are not limited to:

- i) performing the role of Occupational Health and Safety coordinator,
- ii) safety reporting,
- iii) performing risk assessments,
- iv) communication with regulatory authorities on behalf of the client, and
- v) accident and incident investigation.

4 PRINCIPLES

G 4.1.2 Менежментийн болон удирдлагын бус байнгын болон түр ажилчид, тэдгээрийн төлөөлөгчдөөс гадна ХЭМАБ гэрчилгээ авах сонирхолтой талуудад дараахь зүйлс орно, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй:

- i) Хууль эрх зүйн болон зохицуулах байгууллагууд (орон нутгийн, үндэсний, бүс нутгийн эсвэл олон улсын),
- ii) Толгой байгууллага,
- iii) Ханган нийлүүлэгч, гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч,
- iv) Ажилчдын байгууллага (үйлдвэрчний эвлэл), ажил олгогчдын байгууллага,
- v) Байгууллагын өмчлөгчид, хувьцаа эзэмшигчид, үйлчлүүлэгчид, зочид, ажилчдын төрөл төрөгсөд, нутгийн иргэд, олон нийт,
- vi) Хэрэглэгчид, эмнэлгийн болон бусад олон нийтийн үйлчилгээ, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний байгууллага, бизнесийн түнш болон төрийн бус байгууллага (ТББ), болон
- vii) Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын байгууллага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтнүүд (жишээ нь эмч, сувилагч).

5 ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

G 5.2.3 (Тайлбар 2-т)

Гол сонирхогч талуудад G.4.1.2-т дурдсан нэмэлт талууд багтаж болно.

6 БҮТЦИЙН ШААРДЛАГА

Нэмэлт шаардлага байхгүй.

7 НӨӨЦИЙН ШААРДЛАГА

G 7.1.2 (Тайлбарт)

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны хувьд "техникийн салбар" гэдэг нь ажилтнуудыг ХЭМАБ-н эрсдэлд хүргэж болзошгүй үйл явц,

G 4.1.2 In addition to both managerial and non-managerial permanent and temporary workers, and their representatives, parties that have an interest in an OH&SMS certification include, but are not limited to:

- i) legal and regulatory authorities (local, regional, national or international),
- ii) parent organizations,
- iii) suppliers, contractors and subcontractors,
- iv) workers' organizations (trade unions) and employers' organizations,
- v) owners, shareholders, clients, visitors, relatives of workers, local community and neighbours of the organization and the general public,
- vi) customers, medical and other community services, media, academia, business associations and non-governmental organizations (NGOs), and
- vii) occupational health and safety organizations and occupational safety and health-care professionals (for example doctors and nurses).

5 GENERAL REQUIREMENTS

G 5.2.3 (In note 2)

The key interests may include the additional parties mentioned in clause G.4.1.2.

6 STRUCTURAL REQUIREMENTS

No additional requirement.

7 RESOURCE REQUIREMENTS

G 7.1.2 (in the note)

For Occupational Health and Safety management systems, the term "technical area" is related to commonalities of processes or services and their

үйлчилгээний нийтлэг шинж чанарууд болон тэдгээртэй холбоотой аюулууд хамаарна.

8 МЭДЭЭЛЛИЙН ШААРДЛАГА

G 8.5.3 Хуулийн хүчин төгөлдөр зохицуулалт нь эрх бүхий зохицуулагч байгууллагын оролцоо шаардлагатай ноцтой осол эсхүл зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд баталгаажсан үйлчлүүлэгч нь баталгаажуулалтын байгууллагад цаг алдалгүй мэдэгдэхийг мөн шаардана.

9 ҮЙЛ ЯВЦЫН ШААРДЛАГА

9.1 Баталгаажуулалтын өмнөх үйл ажиллагаа

G 9.1.1 Баталгаажуулалтын байгууллагад өргөдөл гаргагч байгууллагын эрх бүхий төлөөлөгчөөс тус байгууллагын үйл явц, үйл ажиллагааны талаар өгөх мэдээлэлд үйл явцтай холбоотой гол аюул, ХЭМАБ-н эрсдэл, үйл явцад ашиглаж буй гол аюултай материал, ХЭМАБ-н холбогдох хууль тогтоомжоос үүдэлтэй аливаа холбогдох хууль эрх зүйн үүрэг мөн багтана.

Өргөдөл нь тухайн байгууллагад ажиллаж байгаа болон байгууллагын байрнаас хол ажиллаж буй ажилтнуудын дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан байна.

G 9.1.4 ХЭМАБ -н аудитын хугацааг IAF MD5-ын дагуу тодорхойлно.

Хэрэв үйлчлүүлэгч өөр байгууллагын байранд үйлчилгээ үзүүлж байгаа бол ТҮБ нь үйлчлүүлэгчийн ХЭМАБ -н үйл ажиллагаа нь газар дээрх эдгээр үйл ажиллагааг хамарч байгаа эсэхийг (бусад байгууллагын ХЭМАБ-н хариуцлагыг үл харгалзан) шалгана. Аудит хийх хугацааг тодорхойлохдоо ТҮБ нь эдгээр ажилтнуудын ажиллаж байгаа аливаа байгууллагын газар дээр үе үе аудит хийх талаар анхаарч үзнэ. Бүх байршилд аудит хийх

associated hazards which can expose workers to OH&S risks.

8 INFORMATION REQUIREMENTS

G 8.5.3 The legally enforceable arrangements shall also require that the certified client informs the Certification Body, without delay, of the occurrence of a serious incident or breach of regulation necessitating the involvement of the competent regulatory authority.

9 PROCESS REQUIREMENTS

9.1 Pre-Certification Activities

G 9.1.1 The information provided to the Certification Body by the authorized representative of the applicant organisation on its processes and activities shall also include the identification of the key hazards and OH&S risks associated with processes, the main hazardous materials used in the processes, and any relevant legal obligations coming from the applicable OH&S legislation.

The application shall contain details of personnel working on, as well as working away from the organisation's premises.

G 9.1.4 The audit time of OH&SMS audits shall be determined in accordance with IAF MD5.

If the client provides services at another organisation's premises, the CAB shall verify that the client's OH&SMS covers these offsite activities (notwithstanding the OH&SMS obligations of the other organization). In determining the time to be spent for audit, the CAB shall consider to audit periodically any organization site where these employees work. Whether all sites shall be audited will depend on various factors such as OH&S risks associated with the activities therein performed,

эсэх нь тэдгээрийн гүйцэтгэсэн үйл ажиллагаатай холбоотой ХЭМАБ-н эрсдэл, гэрээ, гэрээний нийцэл, өөр итгэмжлэгдсэн ТҮБ-аар баталгаажсан эсэх, дотоод аудитын тогтолцоо, осол болон ослын статистик зэрэг олон хүчин зүйлээс шалтгаална. Ийм шийдвэрийн үндэслэлийг тэмдэглэж, бүртгэнэ.

G 9.1.5 Олон салбар (байршилд)-т хэрэгжиж буй ХЭМАБМТ-ны хувьд баталгаажуулалтын хамрах хүрээнд салбар тус бүрт явуулж буй үйл ажиллагаа, үйл явцын шинж чанартай холбоотой ХЭМАБ-н эрсдлийн үнэлгээ, түвшинд үндэслэн түүвэрлэлт хийх эсэхийг тогтоох шаардлагатай. Ийм шийдвэрийн үндэслэл, аудитын хугацааны тооцоолол, салбар тус бүрээр зочлох давтамж нь IAF MD 5-ын 10-р зүйлд заасан шаардлагад нийцэж, үйлчлүүлэгч тус бүрээр баримтжуулсан байна.

Олон салбартай бөгөөд нэг ижил үйл ажиллагаа, үйл явц, ХЭМАБ-н эрсдлийг хамардаггүй бол түүвэрлэлт хийх нь тохиромжгүй.

Хэдийгээр тухайн салбар нь ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг эсвэл бусад салбартай ижил төстэй бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг ч гэсэн ТҮБ нь салбар тус бүрийн үйл ажиллагааны ялгааг (технологи, тоног төхөөрөмж, ашигласан болон хадгалсан аюултай материалын хэмжээ, ажлын орчин, байр гэх мэт) харгалзан үзнэ.

Түүвэрлэлт хийхээр болсон тохиолдолд Баталгаажуулалтын байгууллага нь аудит хийх салбарын түүвэрлэлт нь аудит хийлгэж буй байгууллагад байгаа үйл явц, үйл ажиллагаа, ХЭМАБ-н эрсдлийг төлөөлж байгаа эсэхийг баталгаажуулах ёстой.

Байгууллагын ХЭМАБМТ-нд хамрагдсан түр салбарууд нь менежментийн тогтолцооны үйл ажиллагаа, үр дүнтэй байдлын нотлох баримтыг бүрдүүлэхийн тулд түүврийн

contract agreements, being certified by another accredited CAB, internal audit system, statistics on accidents and near misses. The justification for such decision shall be recorded.

G 9.1.5 In the case of OH&SMS operated over multiple sites it is necessary to establish if sampling is permitted or not based on the evaluation of the level of OH&S risks associated to the nature of activities and processes carried out in each site included in the scope of certification. The rationale of such decisions, the calculation of the audit time and the frequency of visiting each site shall be consistent with the requirements of clause 10 in IAF MD5, and shall be documented for each client.

Where there are multiple sites not covering the same activities, processes and OH&S risks, sampling is not appropriate.

Although a site performs similar processes or manufactures similar products to other sites, the CAB shall take account of the differences between the operations of each site (technology, equipment, quantities of hazardous materials used and stored, working environment, premises etc.).

When sampling is permitted the CB shall ensure that the sample of sites to be audited is representative of processes, activities and OH&S risks that exist in the organization to be audited.

Temporary sites covered by the organization's OH&SMS are subject to audit on a sample basis to provide evidence of the operation and effectiveness

үндсэн дээр аудитад хамрагдана (IAF MD 5-ын 9-р заалтыг үзнэ үү).

9.2 Аудитын төлөвлөлт

G 9.2.1.2 b) Менежментийн тогтолцооны чадварыг тодорхойлохын тулд үйлчлүүлэгчийг холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын болон гэрээний шаардлагыг хангаж байгаа эсэхийг Хавсралт А-д заасан аргыг хэрэглэнэ.

G.9.2.1.3 ХЭМАБМТ нь байгууллагын ХЭМАБМТ-ны үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц хяналт эсвэл нөлөөллийн хүрээнд үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээг багтаана.

Түр салбарууд, тухайлбал, барилгын талбай зэрэг нь хаана байрлаж байгаагаас үл хамааран эдгээр талбайд тавих хяналтыг байгууллагын ХЭМАБМТ-нд хамруулна.

9.3 Анхдагч баталгаажуулалт

Нэмэлт шаардлага байхгүй.

9.4 Аудитыг гүйцэтгэх

G 9.4.4.2 Аудитын баг дараах ажилтнуудтай ярилцлага хийнэ. Үүнд:

- i) Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын талаар хууль ёсны хариуцлага хүлээсэн удирдлага,
- ii) Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хариуцах ажилтны төлөөлөгч(үүд),
- iii) ажилчдын эрүүл мэндийг хянах үүрэгтэй ажилтнууд, тухайлбал эмч, сувилагч. Алсын зайнаас ярилцлага хийх үндэслэлийг тэмдэглэнэ.
- iv) менежерүүд, байнгын болон түр ажилчид.

Ярилцлагад хамрагдах ёстой бусад ажилтнууд:

of the management system (see clause 9 of IAF MD5).

9.2 Planning Audits

G 9.2.1.2 b) For the determination of the ability of the management system to ensure the client meets applicable statutory, regulatory and contractual requirements, the approach described in Appendix A shall be applied.

G 9.2.1.3 The OH&SMS shall include activities, products and services within the organization's control or influence that can impact the organization's OH&SMS performance.

Temporary sites, for example, construction sites, shall be covered by the OH&SMS of the organization that has control of these sites, irrespective of where they are located.

9.3 Initial Certification

No additional requirement.

9.4 Conducting Audits

G 9.4.4.2 The audit team shall interview the following personnel:

- i) the management with legal responsibility for Occupational Health and Safety,
- ii) employees' representative(s) with responsibility for Occupational Health and Safety,
- iii) personnel responsible for monitoring employees' health, for example, doctors and nurses. Justifications in case of interviews conducted remotely shall be recorded,
- iv) managers and permanent and temporary employees.

Other personnel that should be considered for interview are:

- i) хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй менежер, ажилтнууд,
- ii) гэрээлэгчийн удирдлага, ажилчид.

G 9.4.5.3 Баталгаажуулалтын байгууллага нь холбогдох зохицуулалтын шаардлагад нийцэхгүй байгааг илрүүлсэн тохиолдолд авах арга хэмжээг нарийвчлан тодорхойлсон журамтай байна. Эдгээр журамд энэ төрлийн үл нийцэл гарсан тохиолдолд аудит хийлгэж буй байгууллагад нэн даруй мэдэгдэх шаардлагыг тусгасан байна.

G 9.4.7.1 Байгууллагын төлөөлөгч нь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хуулийн дагуу хариуцах удирдлага, ажилтны эрүүл мэндэд хяналт тавих ажилтан, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах үүрэгтэй ажилтны төлөөлөгч(үүд)-ийг хаалтын хуралд урьж оролцуулна. Оролцоогүй тохиолдолд үндэслэлээ тэмдэглэнэ.

9.5 Баталгаажуулалтын шийдвэр

Нэмэлт шаардлага байхгүй.

9.6 Баталгаажуулалтыг хадгалах

G 9.6.4.2 Баталгаажуулалтын байгууллага хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой ноцтой тохиолдол, тухайлбал, ноцтой осол, ноцтой зөрчил гарсныг мэдсэн тохиолдолд менежментийн тогтолцоо нь задраагүй, үр дүнтэй ажиллаж байсан эсэхийг судлах зорилгоор зохицуулалтын эрх бүхий байгууллагын оролцооноос үл хамааран тусгай аудит хийх шаардлагатай байж болно. Баталгаажуулалтын байгууллага нь шалгалтынхаа /investigation/ үр дүнг баримтжуулна.

G 9.6.5.2 Баталгаажсан үйлчлүүлэгчийн өгсөн (G 8.5.3-ыг үзнэ үү) эсвэл тусгай аудитын үеэр аудитын багийн шууд цуглуулсан ноцтой

- i) managers and employees performing activities related to the prevention of Occupational Health and Safety risks, and
- ii) contractors' management and employees.

G 9.4.5.3 The Certification Body shall have procedures detailing the actions to be taken in the event that it discovers a non-compliance with relevant regulatory requirements. These procedures shall include a requirement that any such non-compliances are immediately communicated to the organization being audited.

G 9.4.7.1 The organization representative shall be requested to invite the management legally responsible for occupational health and safety, personnel responsible for monitoring employees' health and the employees' representative(s) with responsibility for occupational health and safety to attend the closing meeting. Justification in case of absence shall be recorded.

9.5 Certification Decision

No additional requirement.

9.6 Maintaining Certification

G 9.6.4.2 Independently from the involvement of the competent regulatory authority, a special audit may be necessary in the event that the Certification Body becomes aware that there has been a serious incident related to occupational health and safety, for example, a serious accident, or a serious breach of regulation, in order to investigate if the management system has not been compromised and did function effectively. The Certification Body shall document the outcome of its investigation.

G 9.6.5.2 Information on incidents such as a serious accident, or a serious breach of regulation necessitating the involvement of the competent

осол, зохицуулагч эрх бүхий байгууллагын оролцоо шаардлагатай ноцтой зөрчил зэрэг тохиолдлын талаарх мэдээлэл (G 9.6.4.2), тогтолцоо нь ХЭМАБ-н баталгаажуулалтын шаардлагыг ноцтой хангаагүй нь нотлогдсон тохиолдолд баталгаажуулалтыг түдгэлзүүлэх, цуцлах зэрэг холбогдох ямар арга хэмжээ авах талаар Баталгаажуулалтын байгууллага шийдвэрийн үндэслэлээ гаргана. Ийм шаардлагууд нь ТҮБ болон байгууллагын хооронд байгуулсан гэрээний нэг хэсэг байна.

9.7 Маргаан

Нэмэлт шаардлага байхгүй.

9.8 Гомдол

Нэмэлт шаардлага байхгүй.

9.9 Үйлчлүүлэгчийн бүртгэл

Нэмэлт шаардлага байхгүй.

10 БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нэмэлт шаардлага байхгүй.

regulatory authority, provided by the certified client (see G 8.5.3) or directly gathered by the audit team during the special audit, (G 9.6.4.2) shall provide grounds for the Certification Body to decide on the actions to be taken, including a suspension or withdrawal of the certification, in cases where it can be demonstrated that the system seriously failed to meet the OH&S certification requirements. Such requirements shall be part of the contractual agreements between the CAB and the organization.

9.7 Appeals

No additional requirement.

9.8 Complaints

No additional requirement.

9.9 Client Records

No additional requirement.

10 MANAGEMENT SYSTEM REQUIREMENTS FOR CERTIFICATION BODIES

No additional requirement.

**Хавсралт А (норматив) - Итгэмжлэгдсэн
ХЭМАБМТ-ны баталгаажуулалт дахь
хууль, эрх зүйн нийцэл**

A.0 ТАНИЛЦУУЛГА

A.0.1 Олон талын үзэл бодлыг харгалзан үзэхэд "хуульд нийцүүлэх" гэсэн дараахь тодорхойлолтыг ашигладаг: " Зорьсон үр дүнд хүрэхийн тулд хуулийг дагаж мөрддөг байх".

ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны стандартын шаардлагад нийцүүлэн ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны баталгаажуулах нь хууль тогтоомжид нийцэж байгаагийн баталгаа биш юм (төрийн болон бусад төрлийн хяналт ба/эсвэл хууль тогтоомжийн нийцлийн шалгалт эсвэл бусад төрлийн баталгаажуулалт, баталгаажилт зэрэг хяналтын бусад арга хэрэгсэлийг агуулдаггүй) , энэ нь хууль эрх зүйн нийцлийг хангах, хадгалахад батлагдсан, үр дүнтэй хэрэгсэл юм.

Итгэмжлэгдсэн ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны баталгаажуулалт нь бие даасан гуравдагч тал (Баталгаажуулалтын байгууллага) нь тухайн байгууллага өөрийн бодлогын амлалт, түүний дотор хууль тогтоомжид нийцсэн байдлыг хангахуйц үр дүнтэй ХЭМАБ-ын менежментийн тогтолцоотой болохыг үнэлж, баталгаажуулсан болохыг нотлох ёстой гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

Холбогдох хууль тогтоомжийн шаардлагад нийцэхгүй байгаа эсвэл болзошгүй үл нийцэл нь тухайн байгууллага болон ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны удирдлагын хяналт дутмаг байгааг харуулж болзошгүй тул стандартад нийцэж байгаа эсэхийг сайтар нягталж үзэх хэрэгтэй.

**Appendix A (normative) - Legal
compliance as a part of accredited
OH&SMS certification**

A.0 INTRODUCTION

A.0.1 Considering the various viewpoints, the following definition for “legal compliance” is used: “Conformity with the law, in such a way that the intended outcome is realised.”

While certification of an OH&SMS against the requirements of the applicable OH&SMS standard is not a guarantee of legal compliance (neither is any other means of control, including government or other type of control and/or legal compliance inspections or other forms of certification or verification), it is a proven and efficient tool to achieve and maintain such legal compliance.

It is recognised that accredited OH&SMS certification shall demonstrate that an independent third-party (Certification Body) has evaluated and confirmed that the organisation has a demonstrably effective OH&SMS to ensure the fulfilment of its policy commitments including legal compliance.

Ongoing or potential non-compliances with the applicable legal requirements might show a lack of management control within the organisation and its OH&SMS and the conformity with the standard should be carefully reviewed.

A.0.2 Энэхүү хавсралт нь EA-7/04 M: 2017 “Итгэмжлэгдсэн ISO 14001:2015 баталгаажуулалтын нэг хэсэг болох хууль эрх зүйн нийцэл” баримт бичгийн сонгогдсон 2017 оны 5-р сарын 03-ны өдрийн эдгээр шаардлагуудыг ХЭМАБ-ын менежментийн тогтолцоонд нэвтрүүлэхэд зориулагдсан болно. Ийм шаардлагууд нь байгууллагын итгэмжлэгдсэн ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны баталгаажуулалт болон тухайн байгууллагын ХЭМАБ-н хууль эрх зүйн шаардлагад нийцэж буй байдлын хоорондын хамаарлыг тодорхойлдог.

A.1 БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГА НЬ ХЭМАБ-ЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН НИЙЦЛИЙН АУДИТЫГ ХЭРХЭН ЯВУУЛАХ ВЭ

A.1.1 Баталгаажуулалтын байгууллага нь баталгаажуулалтын үнэлгээний үйл явцаар тухайн байгууллагын ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг хууль эрх зүйн нийцэлтэй холбоотой үнэлж дүгнэх бөгөөд эдгээр шаардлагад нийцэж байгаа нь нотлогдох хүртэл гэрчилгээ олгохгүй.

Баталгаажуулсны дараа баталгаажуулалтын байгууллагаас хийх дараагийн хяналт шалгалт, магадлан үнэлгээний аудит нь дээрх аудитын аргачлалтай нийцсэн байна.

A.1.2 Баримт бичиг, бүртгэлийг хянах, үйл ажиллагааны явцад ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны хэрэгжилтийг үнэлэх (жишээ нь, байгууламж болон бусад ажлын талбайтай танилцах) хоорондын тэнцвэрт байдлын хувьд Баталгаажуулалтын байгууллага нь ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны үр дүнтэй байдалд зохих аудит хийсэн эсэхийг баталгаажуулна.

A.0.2 This Appendix is intended to extend to OH&SMS the applicability of selected requirements of document EA-7/04 M: 2017 “Legal Compliance as a part of Accredited ISO 14001:2015 certification”, rev.03 May 2017. Such requirements describe the relationship between an organisation's accredited OH&SMS certification and that organisation's degree of compliance with applicable OH&S legal requirements.

A.1 HOW SHOULD A CERTIFICATION BODY AUDIT AN OH&SMS WITH RESPECT TO LEGAL COMPLIANCE

A.1.1 Through the certification assessment process, a Certification Body shall evaluate an organisation's conformity with the requirements of an OH&SMS standard as they relate to legal compliance and shall not grant certification until conformity with these requirements can be demonstrated.

After certification, the subsequent surveillance and reassessment audits conducted by the Certification Body shall be consistent with the above audit methodology.

A.1.2 With respect to the balance between review of documents and records and the evaluation of the OH&SMS implementation during operational activities (e.g. tour of facilities and other work sites), the Certification Body shall ensure that an adequate audit of the effectiveness of the OH&SMS is undertaken.

A.1.3 Байгууллага бүрт нөхцөл байдал өөр өөр байдаг тул харьцангуй харьцаа ямар байхыг тодорхойлох томъёо байхгүй. Гэсэн хэдий ч оффис дээр суурилсан хяналт шалгалтад хэт их цаг зарцуулдаг нь тодорхой давтамжтай тохиолддог асуудал юм. Энэ нь хууль эрх зүйн нийцлийн асуудлаар ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны үр нөлөөг хангалтгүй үнэлж, муу гүйцэтгэлийг анзаарахгүй, баталгаажуулалтын үйл явцад оролцогч талуудын итгэлийг алдахад хүргэж болзошгүй юм.

Баталгаажуулалтын байгууллага нь зохих магадлан хяналтын хөтөлбөрөөр дамжуулан баталгаажуулалтын мөчлөгийн хугацаанд буюу ихэвчлэн гурван жилийн хугацаанд тохирлыг хадгалж байгаа эсэхийг баталгаажуулна. Баталгаажуулалтын байгууллагын аудиторуд нь зөвхөн төлөвлөсөн эсвэл хүлээгдэж буй үр дүнд тулгуурлах бус, тогтолцооны бодит хэрэгжилтэд үндэслэн хууль тогтоомжийн нийцлийн удирдлагыг шалгах ёстой.

